


Хувьцаа эзэмшигчдэд хүргэх захидал – 2022.06.28

Эрхэм хувьцаа эзэмшигчид ээ,

Өнгөрсөн жилүүдэд Монгол Улсын баруун өмнөд бүсэд өндөр агуулга бүхий алтны шинэ дүүргийг нээн илрүүллээ. Бидний гүйцэтгэсэн харьцангуй гүехэн хайгуулын хөтөлбөрийн амжилттай үр дүнгүүд, Төв Азийн Орогенийн бүсийн дагуух бусад томоохон ордуудтай харьцуулан дүгнэхэд Хөндий Алтны Дүүрэг нь олон сая унцын нөөц бүхий дэлхийн хэмжээний ордуудыг агуулах боломжтой юм. 2022 онд бид алтны нөөцийг хоёр сая унцад хүргэх, хайгуулын хөтөлбөрөөр тэлэх боломжуудыг тодорхойлох, Баян Хөндий төслийг олборлолтын шат руу хөгжүүлэх зорилтын дагуу ажиллаж байна.


ТӨВ АЗИЙН ОРОГЕНИЙН БҮС ДЭХ ТОМООХОН АЛТ-ЗЭСИЙН ОРДУУД



Хөндий Алтны Дүүрэг – Дөрвөн шинэ нээлт болон хэтийн төлөв бүхий талбай

Арав гаруй жилийн өмнө Алтан Нар ордыг нээн илрүүлснээс хойш геологийн баг маань алтны чулуулгийн сорьцлолтоор Баян Хөндий ордыг 2015 онд нээн илрүүлсэн. Үүнээс хойш бид дээрх талбайнуудад газрын гадаргаас 150 метрт дунджаар 2 г/т алтны агуулга бүхий ихээхэн нөөцийг тодорхойлсон. Мөн эдгээр төслүүдийг хөгжүүлэх боломжийг тодорхойлох техникийн болон байгаль орчны судалгаануудыг гүйцэтгэж ээ.

Нөөцийн зорилт



2020 онд ноён Эрик Спроттын оролцсон 20 сая кан.долларын хөрөнгө оруулалтыг татан төвлөрүүлснээс хойш Баян Хөндийтэй зэргэлдээ орших Улаан тусгай зөвшөөрлийг 100% эзэмших болсноор Эрдэнэ Ресурсийн техникийн баг энэхүү шинэ дүүрэгт илүү өргөн хүрээнд хайгуулын хөтөлбөр гүйцэтгэх боломжтой болсон. 2020 оны эхэн үеэс бид дөрвөн шинэ нээлт хийж, хайгуулын онцгой үр дүнгүүдийг танилцуулсан:


Алтан Нар: 2020 онд хийсэн өрөмдлөгөөр 17 г/т алтны агуулга бүхий 23 метрийн интервал огтолсон бөгөөд үүний 7 метрийн интервал нь 70 метрийн босоо гүнд 45.7 г/т алт, 93.4 г/т мөнгө, 1.54% хар тугалга, 3.4% цайрын агуулгатай байсан (TND-135) нь Нээлтийн Бүсийн өндөр агуулга бүхий цөмийг тэлсэн.

Баян Хөндий: 2020 оны дундуур BKD-288 цооногт 11.5 метрийн гүнээс эхлэн 581.6 г/т алтны агуулга бүхий 1 метрийн интервал, түүнийг багтаасан 125.9 г/т алтны агуулга бүхий 5.5 метрийн интервал огтолсон. BKD-288 цооногоос хойд зүгт 40 метрт BKD-274 цооногт 14.9 метрийн гүнд 338 г/т алтны агуулга бүхий 1 метрийн интервал, түүнийг багтаасан 25.6 г/т алтны агуулга бүхий 25 метрийн интервал огтолсон.

Хар Морь: 2021 оны эхэнд нээн илрүүлсэн өндөр агуулга бүхий исэлдсэн хүдрийн нээлтийг 2022 оны нэгдүгээр улиралд гүйцэтгэсэн өрөмдлөгийн хөтөлбөрөөр тэлж, цооногийн (AAD-178) 11 метрээс эхлэн 123.5 г/т алтны агуулга бүхий 5 метр, түүнийг багтаасан 42.8 г/т алтны агуулга бүхий 15 метрийн интервал огтолсон.

Улаан: 2021 оны дундуур гадаргын эрдэсжилтгүй бүсэд бид Зүүн-Өмнөд Улаан нээлтийг хийсэн бөгөөд одоогоор 450 метрийн гүн хүртэл эрдэсжилт тодорхойлоод байна. Өнгөрсөн сард үр дүнг нь танилцуулсан өрөмдлөгийн хөтөлбөрөөр цооногийн 208 метрээс 68.3 г/т алтны агуулга бүхий 3 метр, түүнийг багтаасан 8.1 г/т алтны агуулга бүхий 41 метр интервал (UDH-35) огтолсон нь шинээр тодорхойлсон тэжээгч бүсийн дотор оршиж байна.

ӨНДӨР АГУУЛГА БҮХИЙ ХӨНДИЙ ДҮҮРЭГ – ОНЦЛОХ ИНТЕРВАЛУУД (2020-22)



Баян Хөндий, Алтан Нар ордуудад тодорхойлсон нөөцөөс гадна Хар Морь, Улаан зэрэг шинэ нээлтүүдийн анхан шатны нөөцийг оны эцэст тооцоолохоор төлөвлөж байна. Эдгээр нээлтүүд нь олон чиглэлд нээлттэй хэвээр, бодит цар хүрээг тодорхойлоход нэмэлт өрөмдлөгийн хөтөлбөрүүд гүйцэтгэх шаардлагатай. Бидний огтолсон хүдэржилт нь хоёр сая унц алттай тэнцэх хэмжээний нөөцийг тодорхойлох зорилтод хүргэн, нөөцийг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлнэ гэдэгт итгэлтэй байна. 2022 оны хайгуулын хөтөлбөрүүдийг дараах талбайд гүйцэтгэнэ:

Улаан: Баруун зүгт тэлэх боломжийг судлан, өндөр агуулга бүхий тэжээгч структурыг тодорхойлно. Гуравдугаар улиралд гүйцэтгэх анхан шатны хөтөлбөрөөр нийт 3500 тууш метр өрөмдлөг хийнэ.

Хар Морь: Хар Морь талбайн исэлдсэн бүсийг тодорхойлох зорилгоор урвуу эргэлтэт (RC) өрөмдлөгөөр 277 цооног өрөмдсөн. Гуравдугаар улирлын эхэнд хөтөлбөрийн үр дүнг танилцуулах бөгөөд тэжээгч бүсийг турших алмазан өрөмдлөгийн хөтөлбөрийн мэдээллийг хүргэх болно. 2022 онд Хар Морь талбайд ~4000 тууш метрийн алмазан өрөмдлөг гүйцэтгэхээр төлөвлөж байна.

Баян Хөндий: Ордын урд болон баруун хойд зүгт хязгаарлагдмал судлагдсан талбайд ~1200 тууш метрийн өрөмдлөгийн хөтөлбөр хэрэгжүүлнэ.

Алтан Нар: Нээлтийн Бүсийн өндөр агуулга бүхий талбайг үргэлжлүүлэн тодорхойлох, Хойд Холбоо бүсэд исэлдсэн байдлыг судлахаар гуравдугаар улирлын эцэст 3300 тууш метр өрөмдлөгийн хөтөлбөр төлөвлөсөн.

Дээрх хайгуулын хөтөлбөрийн үр дүнгүүд болон урьд нь дурдсан хайгуулын амжилтуудад тулгуурлан компани 2022 оны эцэст нөөцийн тооцооллыг шинэчлэхээр зорьж байна.

Мөн алтны ордуудаас гадна молибден, зэсийн Зуун Мод орд, тусгай зөвшөөрлийн талбайд хэд хэдэн порфирын зэсийн хэтийн төлөв бүхий талбайтай

Баян Хөндий Алтны Төсөл – Олборлолт руу эрчимтэй хөгжүүлж буй

Өнгөрсөн хоёр жилийн хугацаанд бид ордыг анхан шатны бүтээн байгуулалтын үе шат руу хөгжүүлэхэд сорилт бэрхшээлүүдээс гадна олон боломжууд бий боллоо. Цар тахлын улмаас учирч буй саад бэрхшээлийг үл харгалзан бид өнгөрсөн жил төслийн инженерчлэл болон тусгай зөвшөөрлүүдийг авснаар олборлолт руу эрчимтэй хөгжүүлж байна.

Бүтээн байгуулалтын бэлтгэл ажлуудыг эхлүүлсэн бөгөөд тээвэр логистик болон бараа материалын үнэ тогтворжих үед бүтээн байгуулалтыг бүрэн хэмжээгээр эхлүүлнэ.

Цар тахалтай холбоотой бүтээгдэхүүн нийлүүлэлт, инфляцийн дарамт нь бүх аж ахуйн нэгжид хүндээр тусаж байгаа ч эдгээр нөлөөлөл аажмаар буурч байна. Энэ оны сүүлээр БНХАУ - Монгол Улсын хилийн боомтууд бүрэн нээгдэж, 2023 оны эхээр барилгын үндсэн материал, гангийн өртөг буурна гэж бид таамаглаж байгаа нь бүтээн байгуулалтыг бүрэн эхлүүлэхэд тохиромжтой үе юм

Өнөөгийн нөхцөл байдлаас шалтгаалан бүх төслүүд хүнд үетэй тулгараад байгаа боловч өндөр агуулга бүхий, эдийн засгийн хувьд үр өгөөжтэй Баян Хөндий төслийн хувьд хөгжүүлэлт хийхэд үр ашигтай хэвээр байна. Түүнээс гадна бид алтны хүдэржилтийг үргэлжлүүлэн нээн илрүүлсээр байгаа нь төслийн өгөөжийг нэмэгдүүлэх хүчин зүйл болно.

Төлөвлөсөн боловсруулах үйлдвэрээс хойд зүгт 2.5 км-т газрын дөт гүнд, өндөр агуулгатай Хар Морь талбайд исэлдсэн бүсийг илрүүлсэн нь өндөр агуулгатай

алтны шинэ хүдрийн эх үүсвэрийг бий болголоо. Шинээр нээн илрүүлсэн Улаан нээлттэй хамт Хар Морь бүс нь судлын дагуу болон гүндээ нээлттэй тул үйлдвэрийн хүдэр тэжээлтийг ахиухан нэмэгдүүлэх боломжтой. Дээрх нээлтүүдийг өнөөгийн уурхайн төлөвлөгөөнд тусгах боломжтой эсэхийг судлан, байгууламжуудыг өргөтгөх шаардлагатай эсэхийг тодорхойлоход нэмэлт өрөмдлөгийн хөтөлбөр гүйцэтгэх шаардлагатай. 2022 оны хайгуулын хөтөлбөрийн үр дүнгүүдэд тулгуурлан эдгээр шийдвэрийг гаргана.

Түүнээс гадна, өнөөг хүртэл танилцуулсан хайгуулын амжилтуудаас харахад гравитац эсвэл нуруулдан уусгах аргаар хүдрийг боловсруулах боломж харагдаж байна. ТЭЗҮ-д танилцуулсан үйлдвэрлэлийн нөөцийг тооцоолсноос хойш Хөндий Алтны Дүүрэгт гүйцэтгэсэн хайгуулын хөтөлбөрөөр бидний танилцуулсан хамгийн өндөр агуулгуудыг огтолсон. Эдгээр маш өндөр агуулга бүхий бүсүүдийн дээжийг гравитацын аргаар боловсруулах туршилтаар 43-85% металл авалттай байв. Энэхүү үр дүнгүүдэд тулгуурлан хөгжүүлэлтийн эхэн үед боловсруулах үйлдвэрийн үндсэн хэлхээнд гравитацын аргыг ашиглах талаар нэмэлт судалгаанууд хийх шаардлагатай. RC өрөмдлөгийн үр дүнгүүдэд тулгуурлан хязгаарлагдмал судалгаа хийгдсэн бүсүүдийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэхээр ажиллаж байна. Гравитац болон нуруулдан уусгах аргуудыг ашигласнаар анхан шатны хөрөнгө болон үйл ажиллагааны зардлыг бууруулж, мөнгөн урсгалыг урагшлуулж, төслийн өгөөжийг нэмэгдүүлэх боломжтой. Дээрх хувилбаруудыг үнэлэх судалгааг эхлүүлсэн бөгөөд гуравдугаар улирлын хайгуулын хөтөлбөрийн үр дүнг танилцуулахтай зэрэгцэн эцэслэнэ. Үргэлжлүүлэн дөрөвдүгээр улиралд бид боловсруулах үйлдвэрийн хөгжүүлэлтэд техникийн хүчин зүйлсийг шинэчлэх шаардлагатай эсэхийг тодорхойлох судалгааг гүйцэтгэх болно.

Бид хөгжүүлэлтийн төлөвлөгөөг шинэчлэхийн зэрэгцээ Канадын Экспорт Хөгжлийн Агентлаг (“EDC”), Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банк (“EBRD”), Монголын арилжааны банкууд болон төслийн санхүүжилтийн багцыг төвлөрүүлэхэд хамтран ажиллах хүсэлт ирүүлсэн түншүүдтэй санхүүжилтийн багцыг эцэслэхээр ажиллаж байна.

Оролцогч талууд

Өнгөрсөн хорин таван жилийн турш надад Монгол Улсад ажиллах том завшаан тохиосон. Би Монгол Улс социализмаас түүх соёлоо хадгалан чөлөөт зах зээлийн эдийн засагт эрч хүчтэй шилжсэн шилжилтийн гэрч болж, дэлхийн хамгийн том ордуудын нэгийг нээн илрүүлж, хөгжүүлэхийн зэрэгцээ энэхүү бүс нутагт нүүдэлчин амьдралын хэв маяг тасралтгүй үргэлжилж байгааг гэрчиллээ.

Бид хайгуулын амжилтандаа тулгуурлан оролцогч талууддаа үр өгөөж бүхий төсөл хөгжүүлэх бүрэн боломжтой. Энэхүү амжилт нь монгол мэргэжилтнүүдээр ахлуулсан удирдлагын баг, хамт олонтой салшгүй холбоотой. Манай алсын хараа

нь удирдлагын баг болон ТУЗ-ийг монгол мэргэжилтнүүдээр бүрдүүлэх юм. Энэхүү зорилт биелэх бүрэн боломжтойг Оюу Толгой төслийн 16,300 гаруй ажиллах хүчний 97% нь Монгол мэргэжилтнүүд байгаагаас харж болно.

Бидний алсын хараа нь Монгол Улсын иргэдэд байгалийн баялгаас өгөөж хүртэх боломжийг бий болгоход чиглэдэг. Ийм ч учраас бид Монгол болон Торонтогийн хөрөнгийн биржид давхар бүртгэлтэй анхны бөгөөд одоогоор цорын ганц компани болсон. Өнөөдөр манай компани орон нутгийн иргэдийг оролцуулан 7,000 гаруй Монгол хувьцаа эзэмшигчидтэй.

Бид өгөөжийг бүх талууд харилцан хүртэх, ил тод байдал болон боловсролыг хамгийн ихээр чухалчилж ажилладаг. Хэдийгээр манай төслийн талбайн ойролцоо хот суурин байхгүй боловч илүү өргөн бүсэд амьдарч буй иргэд байгаль орчин, тоосжилт, ус болон химийн бодисын хэрэглээний тухай санал хүсэлтүүдээ ирүүлдэг. Бид Монгол Улсын хууль дүрмийн дагуу болон олон улсын стандартын дагуу оролцогч талуудад нөлөөлөх байдлын талаар байгаль орчин, нийгмийн нөлөөллийн судалгаануудыг гүйцэтгэсэн. Бид орон нутгийн иргэдтэй худаг нөхөн сэргээх, шинэ худаг гаргах зэргээр хамтран ажилладаг бөгөөд боловсруулах үйлдвэрийн усны 85%-ийг дахин ашиглах технологи төлөвлөсөн. Түүнээс гадна сэргээгдэх эрчим хүчийг эрчим хүчний шийдлийн нэг хэсэг болгон, орон нутгийн засаг захиргааны байгууллагуудтай эрүүл мэнд, боловсролын чиглэлээр олон төслүүдэд хамтрах, санхүүжүүлж ажиллахаар хамтын ажиллагааны гэрээ байгуулсан. 2020 оны ТЭЗҮ-д тусгагдсанаар Баян Хөндий Алтны Төсөл нь зургаан жилийн хугацаанд 400 гаруй шинэ ажлын байрыг бий болгон, Монгол Улсын Засгийн газарт 100 гаруй сая ам.долларын татвар, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг төвлөрүүлнэ. Бид үйл ажиллагаагаа амжилттай тэлснээр оролцогч талуудын хүртэх өгөөж өсөн нэмэгдэх болно.

Одоогийн орон нутагт хэрэгжүүлж буй төслүүдээс гадна бүс нутагт урт хугацаанд тогтвортой ажлын байр бий болгох, орон нутагт үнэ цэн авч ирэх, хөгжлийг дэмжих төслүүдийг судлан, үнэлгээ хийсээр байна.

Дүгнэлт

Манай компани тогтвортой, олон улсыг хамарсан хувьцаа эзэмшигчидтэй. Өнгөрсөн хоёр жилийн хугацаанд ноён Эрик Спротт болон Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банк нь манай хамгийн том хувьцаа эзэмшигчид болсон төдийгүй бид Канад, Монгол Улсад хувьцаа эзэмшигчдийнхээ тоог тэлсээр байна. Дээрх хувьцаа эзэмшигчид нь нийт гаргасан хувьцааны тал хувийг эзэмшдэг бөгөөд урт хугацаанд хөрөнгө оруулж буй хөрөнгө оруулалтын сангууд, компанийн удирдлага, ТУЗ зэрэг урт хугацааны дэмжигчид нийт хувьцааны гуравны хоёр хувийг эзэмшдэг.

Бидний эрхэм зорилго нь хөрөнгө оруулагчдад үнэ цэнийг бүтээхээс гадна бүх оролцогч талуудад өгөөжийг бий болгох юм. Бид бүгд олон сая унц илрүүлэх

боломжтой шинэ алтны дүүргийн хөгжүүлэлт болон тэлэлтээс өгөөж хүртэх боломжтой.

Бидний богино хугацааны төлөвлөгөөнд нөөцийг нэмэгдүүлэх, шинэ боломжуудыг үнэлж судлах, төсөл хөгжүүлэлттэй холбоотой анхан шатны нөөцийг бэлтгэх ажлуудаас гадна олон улсын инфляцийн түвшин, нийлүүлэлтийн орчинтой холбоотой эрсдэлүүдийг тэнцвэржүүлэх зэрэг ажлууд багтаж байна.

Өнөөдрийг хүртэл хүрсэн амжилтандаа бид сэтгэл хангалуун байдаг хэдий ч ирээдүйн амжилтуудыг тэсэн ядан хүлээж байна. Хэдийгээр олон эрсдэл байдаг ч Хөндий Алтны Дүүргийн нээлт нь миний хувьд энэхүү салбарт 35 жил ажилласан хугацааны хамгийн том шагнал юм.

Би бүх хувьцаа эзэмшигчдийнхээ дэмжлэгт талархал илэрхийлмээр байна. Ирэх сарууд болон жилүүдэд бид үнэ цэнийг өсгөн нэмэгдүүлэхээр ажиллах болно. Ингээд би өнгөрсөн 50 жилийн алтны үнийн графикийг танд үлдээе, аливаа түүх ихэвчлэн ирээдүйн үйл явдлын тодорхойлогч байдаг.

АЛТНЫ ҮНЭ, 50 ЖИЛИЙН ГРАФИК



Хүндэтгэсэн,

Петер К. Акерли
Ерөнхийлөгч, гүйцэтгэх захирал
2022 оны 6 сар